ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр Дугаар 63 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.б дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймагт барьж, ашиглалтад оруулсан, нийт 16 нэрийн 7,556,476,411.00 (долоон тэрбум таван зуун тавин зургаан сая дөрвөн зуун далан зургаан мянга дөрвөн зуун арван нэгэн) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан барилга, байгууламж, худаг машин тоног төхөөрөмжийг Хөвсгөл аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Болдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймагт бий болсон үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ

0000185

D:\Huraldaanii material\2020 on\2020.03.10 3r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн
03 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Гэрээний дүн /төгрөгөөр/	Улсын комиссын актын дугаар	Ашиглагч байгууллага	Гүйцэтгэгчийн нэр
1	30 ортой халдварт сүрьеэгийн эмнэлэгийн барилга	1,966,606,580.00	УКД-2019/48	Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг	"Биг Монголиа билдинг" ХХК
2	20 ортой эрүүл мэндийн төвийн барилга	1,250,000,000.00	УКД-2019/35	Шинэ-Идэр сумын Сум дундын эмнэлэг	"Мөрөн Алтай" ХХК
3	Засаг даргын Тамгын газрын барилга	1,148,967,555.00	УКД-2019/74	Баянзүрх сумын ЗДТГ	"Хөвсгөл Бат Чандмань" ХХК
4	Захирагчийн ажлын албаны барилга	1,012,000,000.00	УКД-2019/76	Хатгал Тосгоны Захирагчийн алба	"ХБС" ХХК
5	Ахмадын өргөөний барилга	49,913,226.00	УКД-2019/38	Арбулаг сумын ЗДТГ	"Мөрөн Чандмань Эрдэнэ" ХХК
6	Ахмадын өргөөний барилга	187,534,616.00	УКД-2019/61	Их-Уул сумын ЗДТГ	Хөвсгөл Булаг ХХК
7	Ахмадын өргөөний барилга	99,500,000.00	УКД-2019/62	Рашаант сумын ЗДТГ	"Сондоргоо" ХХК
8	Ахмадын өргөөний барилга	98,025,201.00	УКД-2019/37	Тосонцэнгэл сумын ЗДТГ	"Сондоргоо" ХХК
9	Мөрөн сумын 10-р багт Гүн өрмийн худаг	25,000,000.00	2019/12/19№1	Мөрөн сумын ЗДТГ	"Хөвсгөл Геологи" ХК
10	Мөрөн сумын 11-р багт Гүн өрмийн худаг	25,000,000.00	2019/12/19№2	Мөрөн сумын ЗДТГ	"Хөвсгөл Геологи" ХК
11	Мөрөн сумын 12-р багт Гүн өрмийн худаг	25,000,000.00	2019/12/19№3	Мөрөн сумын ЗДТГ	"Хөвсгөл Геологи" ХК
12	Мөрөн сумын 13-р багт Гүн өрмийн худаг	25,000,000.00	2019/12/19№4	Мөрөн сумын ЗДТГ	"Хөвсгөл Геологи" ХК
13	Бэлчээрийн гүн өрмийн худаг	25,000,000.00	2019/12/19№5	Мөрөн сумын ЗДТГ	"Хөвсгөл Геологи" ХК
14	Соёмбо цогцолбор	539,629,233.00	УКД-2019/85	Шинэ мөрөн Худалдааны Төв ОНӨХК	"Хан Атрибус" ХХК
15	Хог хаягдалын менежментийг сайжруулах машин тоног төхөөрөмж	1,000,000,000.00	төслийн менежерийн баг	Мөрөн Хот Тохижилт Үйлчилгээний төв ХХК	"ДБЧ" ХХК
16	Цагдаагийн газрын хяналтын постын барилга	79,300,000.00	УКД-2019/43	Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар	"Уул Өвгөд" ХХК
	Нийт дүн	**7,556,476,411.00**			
		(долоон тэрбум таван зуун тавин зургаан сая дөрвөн зуун далан зургаан мянга дөрвөн зуун арван нэг)			